



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 12 сарын 02 өдөр

Дугаар А/614

Хэрлэн сум

Шагнаж урамшуулахад
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалтууд, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар шинэчлэн батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын журам”-ын 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг Хэнтий аймагт хэрэгжүүлэх “Гучин сая мод” хөтөлбөрийн хүрээнд аймгийн Засаг даргатай байгуулсан 2022 оны гэрээний үүргээ хангалттай сайн биелүүлж ажилласан сумд, Сум дундын ойн анги, агентлаг байгууллагыг шагнаж, 5,610,000 (таван сая зургаан зуун арван мянга) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Шагнагдах сумд, байгууллагын нэрсийг нэгдүгээр хавсралтаар, зарцуулах хөрөнгийн тооцоог хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн шагнал урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэгийн зардлаас санхүүжүүлж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2022 оны 12 дүгээр сарын 02-ны

..... дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

Зарцуулах хөрөнгийн тооцоо

№	Зардлын нэр	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	Мөнгөн шагнал	11	500,000	5,500,000
2	Жааз	11	10,000	110,000
	Дүн			5,610,000

Аймгийн Засаг даргын 2022
оны 12 дүгээр сарын 02-ны
дугаар захирамжийн хавсралт

Шагнагдах сумд, байгууллагын нэрс

1. Цэнхэрмандал сум
2. Дэлгэрхаан сум
3. Дадал сум
4. Мөрөн сум
5. Баянмөнх сум
6. Бор-Өндөр сум
7. "Хэнтий шинэс" сум дундын ойн анги
8. Хүнс, хөдөө аж ахуйн газар
9. Боловсрол, шинжлэх ухааны газар
10. Байгаль орчин, аялал жуулчлалын газар
11. Аймгийн Засаг даргын Тамгын газрын мэргэжилтэн